ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 17 өдөр Дугаар А/23 Хажуу шинэ ус

Эрх зүйн хөтөч баг томилох тухай

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 14.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд иргэдэд эрх зүйн боловсрол олгох сумын "Эрх зүйн хөтөч" багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Багийн ахлагч: Засаг даргын Тамгын газрын дарга
Насан туршийн боловсролын багш
Нийгмийн даатгалын улсын байцаагч
Улсын бүртгэгч
Хэсгийн төлөөлөгч
Эмнэлгийн эмч
Байгал орчны улсын байцаагч
Өрнөлт багийн засаг дарга
Соёлын төвийн номын санч
Газрын даамал
Татварын улсын байцаагч
Цэцэрлэгийн эрхлэгч
Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Засаг даргын Тамгын газрын архив бичиг хэргийн эрхлэгч
Санхүү албаны дарга
Жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн

2. Сумын нийт иргэдэд хууль эрх зүйн боловсролыг төлөвлөгөөний дагуу мэдээллийн бүх хэрэгслийг ашиглан хүргэхийг багийн бүрэлдэхүүн болон ахлагч (Н.Өлзийтогтох)-д үүрэг болгосугай.

Тус захирамж гарсантай холбогдуулан Сумын Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/33 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Ө.МӨНХ-АМГАЛАН